

**МОНГОЛ УЛС БА БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН
УЛСЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА:
2006-2008 ОНУУДАД**

*М.Хурметхан**

2006-2008 онуудад Монгол Улс ба БНКаЗУлсын харилцаа, хамтын ажиллагаа идэвхтэй явагдаж, хоёр талын харилцааны ач холбогдол бүхий холбогдох зарим айлчлалыг зохион байгуулж, яриа, хэлэлцээ хийх чиглэлээр явагдан, амжилт олсон он жилүүд билээ.

2006 оны тухайд

Монгол, Казахстаны хувьд олон чухал үйл явдлууд давхцсан харилцааны идэвхтэй жил байлаа. Шанхай хотноо ШХАБ-ын дээд хэмжээний уулзалтын үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Казахстаны Ерөнхийлөгч Н.Назарбаев нар уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар ярилцаж, санал солилцов. Энэ уулзалтын үеэр хоёр орны хооронд олон жил яригдаж байгаа “Казахстаны өр”-ийн асуудлаар ч ярилцсан билээ.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээнд Казахстаны Ерөнхийлөгчийн бие төлөөлөгч бөгөөд Тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд Д.Касейнов, Соёлын сайд Р.Раев болон Парламентын төлөөлөгчид оролцов. Казахстанд зохион байгуулагдсан олон арга хэмжээнд тухайлбал, АХАИБЗ-ий дээд хэмжээний уулзалтад Монгол Улсын Шадар сайд М.Энхсайхан тэргүүтэй төлөөлөгчид, Казахстаны Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Т.Билэгт тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

Монгол Улсын Гадаад Хэргийн сайд Н.Энхболдын урилгаар БНКаЗУ-ын Гадаад хэргийн сайд К.К.Токаев 2006 оны 11 сарын 12-14-нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, Монгол Улс, БНКаЗУ-ын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв, олон улсын болон бүс нутгийн харилцааны харилцан сонирхсон асуудал, ШХАБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд хамтран ажиллах талаар санал солилцож, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх чиглэлүүд, шийдвэрлэх асуудлуудыг хэлэлцлээ. БНКаЗУ-ын Гадаад хэргийн сайдыг дагалдаж ирсэн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд БНКаЗУ-аас БНХАУ-д суугаа бөгөөд Монголыг хавсран хамаарагч Элчин сайд Ж.С.Карибжанов, “Казахстанский холдинг по управление государственными активами”, “Самрук” хувьцаат нийгэмлэгийн захиргааны тэргүүний орлогч Т.А.Кулибаев, “Казахстан

* М.Хурметхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

улсын ардын хадгаламжийн банк”-ны тэргүүлэгч Г.А Марченко, Казахстаны ГХЯ-ны Ази, Африкийн газрын захирал Е.К.Баударбек-Кожатаев нарын хүмүүс ирсэн байна.

Энэхүү айлчлал нь хоёр орны хоорондын харилцаанд чухал нөлөөтэй болж өндөр дээд хэмжээнд яригдаж байсан зарим асуудлыг шийдвэрлэх, харилцааны чиг баримжааг тодрхойлоход чухал ач холбогдолтой болсон билээ.

2006 оны байдлаар хоёр орны хооронд байгуулагдсан 46 гэрээ, хэлэлцээр хэрэгжиж байлаа. Хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгон шинэчлэх ажил хийгдэж байна. Монгол Улсын Ерөнхий сайдын 2006 оны 52 дугаар захирамжаар “Цэргийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНКаЗУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Батлан хамгаалахын сайд нар гарын үсэг зурлаа.

Дорнод Казахстан мужийн захирагч В.В.Храпунов тэргүүтэй төлөөлөгчдийн Монголд айлчилж, Ховд, Увс аймгуудын удирдлагуудтай уулзаж харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон нь манай хоёр улсын бүс нутгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд тустай байна.

Хоёр орны хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаа өргөжижээ. 2004 оноос хоёр улсын худалдаанд ахиц гарч, 2005 онд манай улсаас Казахстанд 552.6 мянган ам.долларын бараа нийлүүлж, импортоор 40 537.9 мянган ам.долларын бараа авсан байна. Энэ өсөлт нь Казахстанас нийлүүлсэн нефтийн бүтээгдэхүүний өсөлттэй холбоотой байв. 2006 оны байдлаар 663 мянган ам.долларын хөрөнгө оруулалт бүхий Монгол-Казахстаны хамтарсан 17 компани манайд бүртгэгдсэн байна. Манай улсад хөрөнгө оруулаад байгаа 72 улсаас Казахстан улс оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр 35 дугаарт орж байв.¹

Ерөнхий сайдын 2006 оны 35 тоот захирамжаар Сангийн дэд сайдаар ахлуулсан “Казахстаны өр”-ийн асуудал зохицуулах ажлын хэсэг байгуулагдав. Казахстаны Гадаад хэргийн сайд К.Токаев Монголд айлчлах үеэрээ, энэхүү өр нь засгийн газар хоорондын шугамаар бий болоогүй ч, “Эрдэнэт” үйлдвэр, Казахстаны “Балхашмыс” үйлдвэрийн хооронд үүссэн өр, төлбөрийн тухай асуудлыг эцэслэн шийдвэрлэх нь хоёр орны хоорондын харилцааны цаашдын хөгжилд ач холбогдолтой гэж үзэж байгаа тухай хэлсэнд үндэслэн энэ асуудлыг шийдэх арга замыг цаашид талууд хамтран судлах, ажиллах нь зүйтэй гэж тохиролцсон байна.

Монгол Улсын иргэний харьяатаас гарах хүсэлтийг шийдвэрлэхэд ажлын хүрээнд хоёрдмол харьяалалтай болсон, харьяатаас гарах, иргэний харьяатаа сэргээлгэх гэсэн хүсэлтийг гаргасан казах иргэдийн асуудал хоёр орны харилцаанд чухал хэвээр байлаа.

2006 онд 912 иргэн МУ-ын иргэний харьяаллаас гарсан байна.

БНКаЗУ-д шилжин суурьшиж Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 28948 казах хүмүүсийг Монгол Улсын ерөнхийлөгчийн 64 удаагийн зарлигаар харьяатаас гаргах ажлыг гүйцэтгэсэн байна. Мөн тус улсын харьяатаас гарсан боловч нүүгээгүй 75 өрхийн 275 хүн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээлгэх хүсэлт гаргасан ба тэдгээр хүмүүст холбогдох материалыг тус алба хянаж 28 өрхийн 106 хүнээс 105 хүнийг иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон байна.

2007 оны тухайд

Монгол Улс, БНКаЗУ-ын хоорондын хамтын ажиллагааны уламжлал, залгамж чанарыг хадгалж, бататган хөгжүүлэх, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг түлхүү анхаарсан он болон тэмдэглэгджээ.

Монгол Улс, БНКаЗУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 15 жилийн ойгоор харилцан баяр хүргэв. БНКазахстан Улстай яриа хэлэлцээ тогтмолжиж, хоёр талын улс төр, эдийн засгийн харилцааг идэвхжүүлэн хөгжүүлэх, бүс нутгийн олон улсын байгууллагууд, тухайлбал, ШХАБ, АХАИБЗ-ий хүрээнд хамтран ажиллах, олон талт эдийн засгийн хамтын ажиллагааны төсөлд хамтран оролцох талаар харилцан санал солилцон ажиллаж байв.

2007 оны хувьд Монгол, Казахстаны харилцаа идэвхжив. Ерөнхийлөгч Н.Энхбаяр БНКаЗУ-ын Ерөнхийлөгч Н.Назарбаевын урилгаар 2007 оны 8 дугаар сард Казахстан улсад төрийн айлчлал хийв. Айлчлалын дүнгээр Хамтарсан мэдэгдэл гаргаж, Монгол, Казахстаны уламжлалт найрсаг харилцааг өргөн хүрээтэй түншлэлийн зарчмаар өргөжүүлэн хөгжүүлэхээр тохиролцож, хамтын ажиллагааны 5 хэлэлцээр, протоколд гарын үсэг зурав.

Хамтарсан Мэдэгдэлд, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Н.А.Назарбаевын урилгаар 2007 оны 8 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Казахстан Улсад Төрийн айлчлал хийв.

Хоёр улсын Төрийн тэргүүн нар (цаашид-Талууд гэж нэрлэх) нөхөрсөг уур амьсгалд хоёр талын харилцааны болон харилцан сонирхсон бүс нутаг, дэлхий нийтийн асуудлаар гүн гүнзгий санал солилцож, байр суурь нэгдмэл байгааг нотлов.

Талууд яриа хэлэлцээ өргөн агуулгатай болсныг сэтгэл ханамжтай тэмдэглээд, тэдгээрийн үр дүн нь хоёр талын хамтын ажиллагаанд шинэ түлхэц өгөх болно гэдэгт итгэл төгс байгаага илэрхийлэв. Талууд Монгол, Казахстаны ард түмнүүдийн найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг удирдлага болгон:

1993 оны 10 дугаар сарын 22-ны өдөр гарын үсэг зурсан Бүгд Найрамдах Казахстан Улс, Монгол Улсын хоорондын Найрсаг

харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ, 1998 оны 3 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан Бүгд Найрамдах Казахстан Улс, Монгол Улсын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх тухай Хамтарсан Тунхаглалын заалтуудыг үндэслэн;

Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын найрсаг харилцааг өргөн хүрээтэй түншлэлийн зарчмаар цаашид хөгжүүлэх нь манай хоёр улс, ард түмнүүдийн язгуур эрх ашигт нийцэж байгааг тэмдэглээд, дараах зүйлүүдийг мэдэгдэж байна:

Талууд бие биеэ харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох зарчмуудад тулгуурлан улс төрийн яриа хэлэлцээгээ тогтмолжуулах, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх чин эрмэлзлээ илэрхийлж байна. Талууд худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны цогц асуудлуудыг шийдвэрлэх, энэхүү салбарын хоёр талын харилцааны тэргүүлэх чиглэл, түүний дотор нэн тэргүүнд худалдаа, эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох үр ашигтай механизм болсон Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын Комиссын гүйцэтгэх үүргийг онцлон тэмдэглэв.

Талууд худалдааны нөхцлийг боловсронгуй болгох, газрын тос, байгалийн хий, зам тээвэр, харилцаа холбоо, олборлох ба боловсруулах аж үйлдвэр, хөдөө аж ахуй, банк зэрэг ирээдүйтэй салбаруудын хамтарсан хөрөнгө оруулалтын төслүүдэд нэн тэргүүнд анхаарал тавьж, харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэхийг эрмэлзэж байна.

Талууд Казахстаны компаниудын оролцоотойгоор Монгол Улсын нутаг дэвсгэр дээр уран, алт, мөнгө, зэсийн хайгуул, олборлолтыг хийх томоохон төслүүдэд хамтран ажиллах нь ирээдүйтэй хэмээн үзэж үүний тулд Монголын эдийн засагт хөрөнгө оруулалт хийх Хамтарсан хөтөлбөр боловсруулах эрмэлзлээ илэрхийлэв.

Талууд Монголд хөрөнгө оруулалтын хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэхэд санхүүгийн чанартай үйлчилгээ шаардлагатайг харгалзан үзээд Казахстаны банкуудын боломжийг Монголын банкны системийг хөгжүүлэхэд ашиглахыг цаашид судлан үзэхэд бэлэн байгаагаа илэрхийлэв. Найрамдалт хоёр ард түмнүүдийн хооронд соёл, хүмүүнлэгийн харилцааг цаашид хөгжүүлэх шаардлагатайг удирдлага болгон соёл, боловсрол, шинжлэх ухаан, залуучуудын талаарх бодлого, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг салбаруудын хамтын ажиллагаанд тэргүүлэх ач холбогдол өгч байгааг Талууд цохон тэмдэглэв.

Урлагийн тоглолт, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, урлагийн хэсэг харилцан солилцох, хоёр улсын нутаг дэвсгэр дээр телевизийн сувгийн нэвтрүүлгийг өргөтгөх, хэвлэлийг харилцан түгээх, оюутан солилцох, түүх соёлын өвийг хамтран судлах,

шинжлэх ухааны хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх зэрэг нь хоёр ард түмний эрх ашгийн тулд соёл, боловсрол, мэдээллийн нийтлэг орчинг бий болгоход тус дөхөм үзүүлнэ гэдэгт Талууд итгэлтэй байна.

Соёлын өдрүүдийг харилцан зохион байгуулах, биеийн тамир, спорт, аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, орон нутгийн шууд харилцаанд дэмжлэг үзүүлэх нь харилцаа, хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой хэмээн Талууд үзэв.

Хоёр улс олон улсын тавцанд хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхийн чухлыг Талууд онцлон тэмдэглээд, хоёр улс гишүүнээр элссэн олон улсын байгууллагуудын хүрээнд байр суурь болон хүчин чармайлтаа зохицуулахаа мэдэгдэв. Талууд НҮБ-ыг дэлхийн аюулгүй байдал, тогтвортой байдлыг бэхжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүдийн эрх тэгш харилцааг хэрэгжүүлэх цорын ганц хэрэгсэл хэмээн үзэж түүний олон улсын үйл хэрэгт гүйцэтгэх үүрэг ролийг бэхжүүлэхийн төлөө байна. Талууд хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн болон үйлдвэрлэлийн чанартай гамшигаас урьдчилан сэргийлэх салбарт хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлэв.

Талууд Азид тогтвортой байдлыг хангах асуудалд чухал ач холбогдол өгч, нийтлэг сонирхлын үндсэн дээр олон улсын терроризм, шашны хэт даврагчид, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус худалдаа, хууль бус зэвсгийн наймаа, хил дамнансан зохион байгуулалттай гэмт хэрэг, цөмийн түүхий эдийн хууль бус наймаа, хууль бус цагаачлал зэрэгтэй олон улсын холбогдох байгууллагуудын хүрээнд хоёр талын үндсэн дээр болон олон талт хэлбэрээр тэмцэхэд бэлэн байгаагаа онцлон тэмдэглэв.

Төв Ази дахь цөмийн зэвсэггүй бүс, Монгол Улсын цөмийн зэвсэггүй статус нь цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмийг бататгаж, улс орнуудын хооронд итгэлцлийг бэхжүүлэх чухал арга болохыг талууд онцлон тэмдэглэв. Монголын тал Төв Азийн цөмийн зэвсэггүй бүсийг дэмжиж байгаагаа нотлов. Казахстаны тал Монголын цөмийн зэвсэггүй статусыг бүрэн дэмжиж байгаагаа мөн илэрхийлэв.

Талууд Азийн бүс нутагт яриа хэлэлцээг дэмжих, мөргөлдөөнөөс сэргийлэхэд чиглэсэн олон улсын бодлогын зэрэг хүчин зүйл болох Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх Зөвлөлгөөн нь чухал үүрэг гүйцэтгэж байгаатай санал нэг байна. Бүгд Найрамдах Казахстан Улс идэвхтэй гишүүн нь болох ШХАБ, ЕАЭЗН зэрэг олон талт хамтын ажиллагааны механизмүүдээр дамжуулан бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцох сонирхолтой байгаагаа Монголын тал илэрхийлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын БН Казахстан Улсад хийсэн айлчлал нь хоёр орны хоорондын найрамдлыг бэхжүүлэх, бүх талын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд чиглэгдсэн чухал үйл явдал болсныг Талууд мэдэгдэж байна гэж өгүүлжээ.

Энэхүү айлчлал нь дээд, өндөр хэмжээний яриа хэлэлцээг үргэлжлүүлж, харилцааны цаашдын чиг хандлагыг тодорхойлох. харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, шинэ шатанд өргөжүүлэн хөгжүүлэхэд үлэмж ач холбогдолтой болсон билээ.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын хамтын ажиллагааны Монгол, Казахстаны Засгийн газар хоорондын комиссын үндэсний хэсгийн дарга нарын ажлын уулзалт 2007 оны 7 дугаар сард Астана хотноо болов. Казахстаны “Балхашмыс” үйлдвэрт нийлүүлсэн зэсийн баяжмалын төлбөр тооцооны асуудлыг янз бүрийн түвшинд хэлэлцсэний дүнд Казахстаны тал төлбөрийг барагдуулах хөрөнгийн эх үүсвэрийг 2008 оны улсын төсөвтөө суулгах үүрэг хүлээсэн меморандум байгуулав.

2007 онд Монгол, Казахстаны хоорондын худалдааны нийт хэмжээ нэмэгдсэн байна. 2007 оны эхний 10 сарын байдлаар хоёр орны хоорондын гадаад худалдааны бараа эргэлт 22291,8 мян.ам.доллар болсон байна. Казахстан-Монголын хоорондын нийт бараа эргэлт -26.5 /2001/, 41.1 /2005/, 51.5 /2006/, 31.0 /2007/ сая ам.доллар байв. Экспорт-0.2 /2004/, 0.6 /2005/, 1.7 /2006/, 0.8 /2007/ , импорт-26.3 /2004/, 40.5 /2005/, 49.8 /2006/, 30.2 /2007/ сая ам.доллар байв.² Манай улсад 72 орноос хөрөнгө оруулаад байгаагаас Казахстан Улс оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр 35 дугаарт байгаа. Монголд Казахстаны 663 мянган ам.долларын хөрөнгө оруулалттай 17 компани бүртгэгдсэн байна.³ Казахстаны хөрөнгө оруулалтын хэмжээ төдийлөн нэмэгдэхгүй байгаа. Казахстаны Гадаад хэргийн сайд К.Токаевын айлчлалын үеэр Казахстаны тал Монголд 1 тэрбум ам.доллар хүртэл хөрөнгө оруулах боломжтой гэж мэдэгдсэн боловч энэ нь өнөөг хүртэл хэрэгжихгүй байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатай байгаа хэвээр үлджээ.

2008 оны тухайд

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Нурсултан Назарбаев 2008 оны 8 сарын 6-7 Монгол Улсад гурав дахь удаагийн айлчлалаар ирсэн билээ. Ерөнхийлөгч Нурсултан Назарбаевын хамт 50 гаруй төлөөлөгчид ирсэн юм. Энэ үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаяр гадаадын зочиддоо олгодог Монголын төрийн хамгийн хүндтэй “Эрдэнийн очир” одонгоор Н.Назарбаевыг шагнасан байна. Уг одонгоор Японы ерөнхий сайд, БНСУ, Унгар Улсын Ерөнхийлөгч, АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга асан Ж.Бейкерийг л шагнаж байсан аж.

Хоёр орны ерөнхийлөгч нар уулзалт, хэлэлцээ хийсний дараа хамтран ажиллах баримт бичгүүдэд гарын үсэг зурсан байна. Үүнд Боловсролын салбарт хамтран ажиллах Гэрээ, Нийгмийн хамгааллын

салбарт хамтын ажиллагаагаа өргөжүүлэх баримт бичиг, Гадаад харилцааны салбарт 2008-2012 онд хамтран ажиллах санамж бичиг зэрэг баримт бичиг оржээ. Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Нурсултан Назарбаев нь Монголд өмнө нь 1993, 1999 онд төрийн айлчлал хийж байсан билээ.

Хоёр орны төрийн тэргүүн нар уулзалтын явцад нэлээд хэд хэдэн зүйл дээр хэлэлцээ нааштай үр дүнд хүрчээ. Монголд 1-1,5 сая тонн түүхий нефтийг нийлүүлэх хүсэлтийг Монголын талаас уламжлахад нааштайгаар хүлээн авч дэмжихээ Н.Назарбаев мэдэгдэв. Мөн түүнчлэн 20-30 мянган тонн улаан буудайг буцалтгүй тусламжаар нийлүүлэх асуудлыг сайтар судлан шийдвэрлэхээ ч амалсан байна. Казахстан нь нүүрс ус, металл, уран, үр тарианы баялаг нөөцтэйгээс гадна олборлолт, ашиглалтаараа дэлхийд тэргүүлэх бүрэн бололцоотой орон билээ. Хоёр орон байгалийн баялаг ихтэйгээрээ төстэй ч тус улс Монголын уул уурхай, банк санхүүгийн салбарыг түлхүү сонирхож хөрөнгө оруулах бололцоотойгоо айлчлалын үеэр уламжилж байлаа. Мөн хоёр орны бизнесийнхэн ч уулзалдаж, бизнесийн хамтарсан зөвлөл байгуулав. Казахстаны “Kazyna Capital Management” компани нь Монгол, Казахстаны хамтарсан санг санал болгов. Уг сан нь 100 сая ам.долларын санхүүжилттэй байх бөгөөд 80 хувийг Казахстаны тал, 20 хувийг Монголын тал бүрдүүлж болно. Уг сангийн хөрөнгөөр Монголд төрөл бүрийн үйлдвэрлэл эрхлэх, төсөл хэрэгжүүлэх боломжтойг тэмдэглэжээ. Монголын талаас Казахстаны хөрөнгө оруулагчдад Баян-Өлгий аймгийн “Цагаан нуур” худалдааны чөлөөт бүсийг санал болгов. Энэ нь Казахстанд ойр бөгөөд татвар бага, зөвшөөрөл авахад хялбар зэрэг бизнесийн таатай нөхцөлтэй ажээ. Хоёр тал олборлох салбарт хамтран ажиллахаар төлөвлөж буйн зэрэгцээ хөдөө аж ахуй, банкны сектор, дэд бүтэц, тээврийн салбарыг хөгжүүлэхэд хоёр талын хэлхээ холбоог бэхжүүлэх сонирхолтойгоо илэрхийлэв. 2007 онд 44 хувиар (30 сая ам.долларт хүрч байсан юм) буурсан хоёр талын худалдааг сэргээхийг Монгол, Казахстан Улсууд эрмэлзэж байна. Астанагаас Улаанбаатар, Баян-Өлгий рүү (Монголын хүн амын дөрвөн хувийг эзэлдэг 160 мянга орчим казах хүн оршин суудаг) нислэг хийх замаар агаарын харилцааг өргөжүүлэх нь зүйтэй гэж үзэв. Монгол, Казахстан Улс газар нутгийн хувьд ойр байдаг ч хил залгаа биш учраас зам харилцаа нь Орос, Хятадын нутгаар дамждаг юм. “Казахстан, Монголын худалдааны өнөөгийн байдалд бид сэтгэл хангалуун биш байна. Тохиромжтой, таатай тээврийн харилцаа байхгүйгээс худалдаа хөгжихөд саад учирч буй юм. Бид Оросын нутгийг дайруулан Казахстан, Монголыг холбосон зам барихаар төлөвлөж байна” гэж Н.Назарбаев мэдэгдсэн билээ.

2008 оны байдлаар Монгол Улсаас Казахстанд 1991-2007 онуудад 88 мянга гаруй иргэд шилжин суурьснаас 30 гаруй мянга

нь Монголын харъяатаас гарч, харъяаллын асуудал нь шийдэгдээгүй олон хүмүүс байсаар байв. Албан ёсны энэхүү айлчлалын үеэр энэ асуудлыг хөндөж иргэншлийг шийдэхэд учирч байгаа саад бэрхшээлийг багасгаж, хялбаршуулах талаар тохиролцжээ. Дэд бүтцийг хөгжүүлэхийг Монголын төрийн тэргүүн санал болгосон байна. Казахстанас Монгол руу зам тавих, Алтайн хөгжил хэмээх төслийг хэрэгжүүлэхдээ хөрш зэргэлдээ ОХУ, Хятадыг оролцуулж тус бүсийг хөгжүүлэх талаар ч санал солилцсон байна.

“Казахстаны Ерөнхийлөгч Нурсултан Абишевич Назарбаев 2008 оны Монгол Улсад хийсэн гурав дахь айлчлал нь улс төрийн чухал зорилготой байсан гэж тухайн үед тэмдэглэж байлаа. Монгол Улсад нэлээд тооны казах иргэн амьдардаг, Монгол, Казахын ард түмний түүх, соёл нь нийтлэг байдаг болохоор Монгол Улс, Казахстан хоёрын харилцаа бусдаас өвөрмөц байдаг нь, биднийг бусдаас арай өөр шижим холбодог нь мэдээж билээ. Казахстаны Ерөнхийлөгч Нурсултан Назарбаев Монголд сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн үйл явдлын дараа Монгол орны дотоодод нь тогтвортой байдлыг бэхжүүлэхэд дөхөм үзүүлэх, олборлох салбарт Казахстаныг эзлэх байртай болоход нь туслах, бүс нутагтаа ч тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилготой айлчлал хийв. Казахстан өөрийн хөрөнгөө Монголд хэрэгжүүлэх төслүүдэд хөрөнгө болгон оруулж, Монгол Улсын байгалийн арвин баялагаас хүртэлцэх боломжийг Казахстаны бизнест нээж, Казахстан улс хөрш орнуудынхаа сэтгэлд юм хийчихэлгүйгээр тэр нөөц рүү алгуур ойртож, Казахстан улс Монголд бэхжээд авахыг оролдож байна гэж үзэх хүмүүс ч байна.”⁴

2008 оны 10 сард Монгол Улс, БНКАУ-ын Засгийн Газрын тэргүүн нар ШХАБ-ын Засгийн Газрын тэргүүн нарын Зөвлөлийн Хуралдааны үеэр уулзан ярилцаж, хоёр орны харилцааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын салбарт хамтран ажиллах болон бусад асуудлаар санал солилцсон байна. Энэ удаагийн уулзалтын үр дүнд Казахстанас түүхий газрын тос болон бэлэн нефть бүтээгдэхүүн худалдаан авах асуудлыг тохирч Санамж бичиг байгуулсан байна. Уг Санамж бичгийн дагуу Монгол Улс 2009 оноос эхлэн жилд 150.0 мянган тонн бэлэн нефть бүтээгдэхүүн, 1.2-2.0 сая хүртэл тонн түүхий газрын тос авахаар тохиролцсон бөгөөд энэхүү санамж бичгийг таван жилийн хугацаагаар байгуулжээ. Казахстанас импортлох нефтийн бүтээгдэхүүнээ БНКАУ-аар дамжуулан авах бөгөөд улмаар импортын нефтийн бүтээгдэхүүний эх үүсвэрээ нэмэгдүүлэх, тонн түүхий газрын тос худалдан авч хөрш орнууд болон цаашдаа дотооддоо боловсруулах, дотоодынхоо хэрэгцээг бүрэн хангах талаар дэвшүүлсэн зорилтын нэг чиглэл хэрэгжих боломж нээгдсэн билээ.

Хоёр орны хооронд энэ хугацаанд урлагийн тоглолт, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, урлагийн хэсэг харилцан солилцох, хоёр улсын нутаг дэвсгэр дээр телевизийн сувгийн нэвтэрүүлгийг өргөтгөх, оюутан солилцох, түүх соёлын өвийг хамтран судлах, соёлын өдөр зохиох зэрэг ажлууд хийгдсэн байна. 2008 оны 10-р сард Казахсан Улсын Соёлын Төв Улаанбаатар хотод нээгдэн ажиллаж, 2008 оны 10-р сарын 2-5-нд Казахстаны соёлын өдрүүд Улаанбаатар хотод зохиогдсон билээ. Тус арга хэмжээнд БНКаЗУлсын Соёл, Мэдээллийн Яамны сайд Мухтар Кул Мухамед тэргүүтэй 65 хүний бүрэлдэхүүнтэй урлаг соёлын баг оролцов. “Күлсара минь баяртай”, “Кек”, “Дүние жарык”, “Мустафа Шокай” зэрэг казахын уран сайхны кинонуудыг үзүүлж, “Эх талын үнэт өв” үзэсгэлэн гаргаж, казахын хамлагуудын тоглолтууд болж, үзэгчдийн талархлыг хүлээсэн байна.

Ийнхүү, 2006-2008 онд хоёр орны харилцаа бүх түвшинд амжилттай хөгжиж ирсэн нь харагдаж байна. Үүнийг гадаадын судлаачдын судалгаа нэгэн адил баталж байгаа бөгөөд “Eurasia Daily Monitor”-д хэвлэгдсэн “Kazakhstan and Mongolia Broooaden Realations”⁵ хэмээх өгүүлэлээс харж болно. Гэхдээ, хамгийн чухал салбар, хөгжүүлэх нь зайлшгүй болох худалдаа, эдийн засгийн харилцаа хангалтгүй хэвээр үлджээ. Тухайлбал, 2007 онд хоёр орны худалдааны нийт эргэлт 70 сая ам.долларт ч хүрэхгүй байсан нь үүнийг гэрчилж байна.⁶

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Гадаад харилцаа” Монгол Улсын ГХЯ-ны мэдээлэлийн товхимол.ГХЯ-ны 2006 оны үйл ажиллагааны тайлан. №2 /178/ т.23-24
2. Монгол Улсын Статистикийн эмхтгэл-2006. УБ., 2007. т.265, 267
3. “Гадаад харилцаа” Монгол Улсын ГХЯ-ны мэдээлэлийн товхимол.ГХЯ-ны 2007 оны үйл ажиллагааны тайлан. №1 /193/ т.18
4. “Н.Назарбаевын айлчлал улс төрийн чухал зорилготой байсан” Р.Жаргалант (2008-08-20) Павел Захаров 05.08.2008
5. John C.K.Daly.Kazakhstan and Mongolia Broooaden Realations”Eurasia Daily Monitor Volume: 5 Issue: 74
6. Егемен Казахстан. Казакстан – Монголия: ЫПАЛДАСТЫКТЫ ТЕРЕНДЕТУГЕ ЫКЫЛАСТЫЛЫК №254-256 (24829) 15 ТАМЫЗ СӨРСЕНБИ 2007 ЖЫЛ